



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 360,000,000.00 (гурван зуун жаран сая) төгрөгт багтаан 2 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Годобчдын чиглэл: 0001992

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 05 ны өдрийн
23 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХУДАЛДАН АВАХ АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ,
ҮННИЙН ДЭЭД ХЯЗГААР

| Д/д | Автомашины техникийн үзүүлэлт | Тоо ширхэг | Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг) | |
|-----|---|---------------|--|--|
| | | | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) |
| 1 | Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 4700 cc | 2 | 180,000,000.00 | 360,000,000.00 |
| | Нийт дүн | | | 360,000,000.00 (гурван зуун жаран сая) |